

БҮЛЭГ I. ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендерийн урилга (ТУ)

Огноо: 2019 оны 2 дугаар сарын 11-ны өдөр

Гэрээний нэр, дугаар: МРЦМ/201901408

Төслийн нэр, дугаар: “Бор-Өндөр” УБҮ-ийн ажиллагсад нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэх”, МРЦМ/201901408

“Монголросцветмет” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг “Бор Өндөр” УБҮ-ийн ажиллагсад нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэх” тухай тендер ирүүлэхийг урьж байна. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 100,000.00 /нэг зуун мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэл

гэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш [45] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба [Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнтэй], тендерийн баталгаатай хамт ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 15:00 цагаас** өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба **мөн өдрийн 15:30 цагт** цахим системээр нээнэ

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 406 тоот өрөө, утас: 450060 + 115

МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК